



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 72

Алтай

**Ажлын албаны бүтэц, орон  
тоо батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны бүтэц, орон тоог 13 хүртэл байхаар тогтоож, хавсралтаар баталсугай.
2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.
3. Хурлын ажлын албаны дотоод журам, ажилтнуудын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан боловсруулж, мөрдөж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Мөнхтөр/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

